

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Д.Батцогт

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн дэд профессор, хурандаа

Товч агуулга: Энэхүү илтгэлээр манай орны эрүүгийн эрх зүйн ялын бодлогод шинээр нэвтэрсэн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч, хяналтын тоног төхөөрөмжийн практик хэрэглээг судалж, тулгамдаж буй асуудлуудыг судалгааны үндсэн дээр нээн илрүүлж, ял эдлүүлэх ажиллагаанд тус дэм болохыг зорилоо.

Түлхүүр үг: Зорчих эрхийг хязгаарлах ял, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, цахим бугуйвч, электрон мониторинг, цахим хяналт.

Abstract: The article is devoted to will soon begin to enforce the restraining punishment of restriction on freedom of travel, implementing and improving critical issues in implementing and improving the use of electronic bracelet used by foreign countries and highlighting some of the issues that need to be addressed.

Key words: electronic bracelet, convict, punishment, electronic monitoring, punishment of restriction on freedom of travel.

Удиртгал

Мэдээлэл, технологийн 21 дүгээр зуунд шинжлэх ухааны бүхий л салбарт олон ололт, амжилтууд шинээр нэвтэрч, нийгэм эдийн засаг, эрх зүйн орчин хурдацтай хувьсан өөрчлөгдөж, хууль зүйн шинжлэх ухаан тэр дундаа эрүүгийн эрх зүйн ялын бодлогын хэрэгжилтийг хангахад аль болох хуучин хэв шинж, биечилсэн хяналтаас татгалзаж, олон шинэлэг аргачлал, дэвшилтэт техник, технологиудыг

туршиж, шат дараалалтайгаар ашиглаж эхэлсээр байна⁴².

Дэлхийн олон улс, үндэстэн эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүнийг даган гарах хууль эрх зүйдээ “хүний эрхийг хангаж, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзаж, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна⁴³.

⁴² Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт

эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2021. 180 дахь тал.

⁴³ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018. 29 дэх тал.

Манай улсын хувьд ч мөн адил хорих ялаас татгалзах, ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон ялыг оновчтойгоор хэрэглэх замаар ял үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас баталсан “Эрүүгийн хууль”-д шинэ төрлийн ял болох “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг нэмж, хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн⁴⁴.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь олон улсын эрүүгийн эрх зүйд “гэмт этгээдийг нийгмээс тусгаарлалгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг” ялын төрлүүд буюу хорихоос бусад төрлийн ялууд дундаас “эрүүгийн хариуцлага, ялын зорилго бүрэн хангагдах боломжтой, гэмт этгээдийг нийгэмшүүлэх өндөр үр нөлөө бүхий ялын төрөл гэдэг”⁴⁵-тэй судлаачийн хувьд санал нэгддэг.

Монгол Улсын “Эрүүгийн хууль”-ийн 5 дугаар зүйлд зааснаар зорчих эрхийг хязгаарлах ял нь агуулгын хувьд:

- “ялтан оршин суух газраас явахыг хориглох, шүүхээс тодорхойлсон газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр явах, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр байнга оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ”;

- “шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно”;

- “Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино”;

- “Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийг шинж чанар, хувийн байдлыг харгалзан зорчих эрхийг хязгаарлах ялаас хөнгөрүүлж, ялаас чөлөөлөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж тус тус зохицуулсан байна.

Давуу тал, ач холбогдол, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлэх боломжит нөхцөлүүд:

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт нэг мөр хангагдсан тохиолдолд нийгмийн хөгжил болон улсын орын эдийн засаг, ард иргэдийн сэтгэхүйд ихээхэн хэмжээний “эерэг өөрчлөлт, хөгжил дэвшил” бий болгох сайн талтайгаас гадна дараах “давуу тал, ач холбогдолтой”-г судлаачийн

⁴⁴ Доктор(Phd) Д.Дамдинцэрэн. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах эмхтгэл”.УБ., 2021.11 дэх тал.

⁴⁵ Ходжалиев. С.А. Теория и практика ограничения свободы как вида наказания.

Грозный., 2019.С.75. России.
/00Ходжалиев.С.А. Зорчих эрхийг хязгаарлах ялын онол, практикийн асуудал. Грозный., 2019. 75 дахь тал. Оросын Холбооны Улс.

зүгээс онцлон тэмдэглэж байна. Тухайлбал:

- Монгол Улсын “Үндсэн хууль”-д тунхагласан ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон “хүний эрхийг дээдлэх” тулгуур зарчимдаа нийцэх;

- Энэ төрлийн ялыг оногдуулж эхлэснээр хорих ангид яд эдэлж буй хоригдогчийн тоо, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардал буурах, улсын төсөвт хэмнэлт хийх;

- Ялтан учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хороо арилгах боломж, бололцоогоор хангагдах;

- Гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэйд төрөхөөс өмнө гурван сар, төрснөөс хойш хоёр жил хүртэл, мөн ганц бие эцэг, эхийг хүүхэд нь хоёр нас хүртэл хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж эдлүүлэх боломж бүрдсэн;

- Хорих ял эдэлсэн хүмүүсийн нэлээдгүй хувь нь “дахин гэмт хэрэг үйлдэх магадлал”-тай байдаг бөгөөд гэмт этгээдийг энэ төрлийн ялаар шийтгэсэн тохиолдолд ялын үр нөлөө дээшилж, нийгэм дэх гэмт хэргийн гаралтын тоо буурах;

- Өсвөр насны хүнд энэ төрлийн ял оногдуулсан тохиолдолд ялын хуцацааг 2 дахин багасгаж эдлүүлэх боломжтой;

- Цахим бугуйвчийг хэрэглэж, ялтанд хяналт тавих систем бүрэн ажиллаж эхэлснээр Монгол улсын хэмжээнд тулгамдсан асуудал болж байгаа “хаягжилт, түүний хэрэглээ”-тэй холбогдох бусад дагавар асуудлуудыг олон улсын жишигт

нийцүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын биелэлтийг хангах хууль эрх зүйн, зохицуулалт.

Энэ төрлийн ялыг хэрэгжилтийг хэрхэн хангах талаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 167-176 дугаар зүйлд дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Мөн хуулийн 167 дугаар зүйлийн 167.1-т “Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа хаяг болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина;

- 167.2-т “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

- 167.3-т “Шийдвэр гүйцэтгэгч, ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

168 дугаар зүйлийн 168.1-т Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан дараах үүрэгтэй:

- Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;

- Шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

- Шүүхээс тогтоосон зорчихыг хязгаарласан газарт зорчихгүй байх;

- Шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа орхихгүй байх;

- Шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар болон бичгээр тайлбар гаргах;

- Тогтоосон журмын дагуу зөөврийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийн хэвийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

- Хувийн бичиг баримтаа биедээ авч явах;

- Ял эдэлж дуусмагц хяналтын тоног төхөөрөмжийг шийдвэр гүйцэтгэгчид бүрэн бүтэн хүлээлгэн өгөх.

170 дугаар зүйлийн “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зорчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих” гэсэн хэсгийн 170.1-т “Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журам”-ыг зөрчсөнд тооцно. Үүнд:

- Энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй;

- Техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагаа сарниулсан;

- Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаанд санаатайгаар зайлсхийсэн;

170.2-т “Дараах тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журам”-ыг ноцтой зөрчсөнд тооцно. Үүнд:

- Энэ хуулийн 168.1-д заасан үүргээ 3 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй;

- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;

- Энэ хуулийн 170.1.2, 170.1.4-т заасан зөрчлийг давтан гаргасан;

- Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;

- Техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

- Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино гэж тус тус заажээ.

Түүнчлэн “Эрүүгийн хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан тохиолдолд ялтны нийт эдлэх ялыг хугацааг хоёр дахин багасгаж, эдлүүлэхээр”;

Гэмт хэрэг үйлдсэн нь баримтаар нотлогдсон этгээд учруулсан хохирлоо нөхөн төлж, засарч хүмүүжсэнээ баталж гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол шүүх зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр;

Ялтан ял эдлүүлэх нөхцөл журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналыг хоног олгохоор тус тус зохицуулсан байна.

Ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх нь хоригдогчийн биеэр эдлэх ялын зардлыг бууруулж, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтнүүдийг нийгэмд хүмүүжүүлэх, сурч боловсрох, улмаар хөдөлмөр эрхлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн барагдуулах боломжийг олгодог шинжээрээ бусдын төрлийн ялуудаас давуу талтай болохыг гадаадын эрдэмтэн, судлчаачид өөрийн бүтээлд дурьдсан байдаг.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд шинэчлэн баталсан “Эрүүгийн хууль”-д “зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг нэмж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжилтийг хангахаар зохицуулсан бөгөөд “тус ялын биелэлтийг хангах, бэлтгэл ажлын хангуулах, техникийн цахим хяналтыг хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээнд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын бүтцэд “Цахим хяналт, удирдлагын төв”-ийг байгуулсан.

Цахим хяналт, удирдлагын төв нь улсын хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд техникийн цахим хяналтыг тасралтгүй тавих, ялтны зүгээс гаргасан “анхааруулга, зөрчил”-ийн мэдээллийг харьяа газар, хэлтэс, байгууллагын холбогдох албан тушаалтанд шуурхай дамжуулах, ялын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангуулах, удирдлагыг нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах, хяналтын тоног төхөөрөмжийг засварлах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний буюу зорчих эрхийг хязгаарлах ялыг шүүхээс оногдуулж эхэлсэн үеэс 08 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд Цахим хяналт, удирдлагын төвийн “зорчих эрхийг хязгаарлах хяналтын систем”-д Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж, хяналтад орсон - 983, Аймаг, нийслэл, сум дундын анхан шатны шүүхийн захирамжаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлж, хяналтад орсон – 77, нийт 1060 ялтан бүртгэгдсэн байна.

Цахим хяналт, удирдлагын төвийн “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д бүртгэгдэж, хяналтад орсон нийт ялтаас ялын

хугацаа дуусч суллагдсан - 74, зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хуцагааг хорих ялаар дүйцүүлж сольсон – 27 ялтан байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэглээ

Монгол Улсын Их Хурлаар шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-д нийт 1088 гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож, **“хорих, торгох, эрх чөлөө хязгаарлах ял, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах”** гэсэн ялын төрлүүдийг **“үндсэн болон нэмэгдэл”** ялын чанартайгаар оногдуулах тухай заасан. Үүнд:

- Хорих ялыг бусад төрлийн ялаас сонгох бололцоогүйгээр /дангаар/ 469 гэмт үйлдэлд оногдуулахаар;


- Торгох ялыг хорих болон бусад төрлийн ялаас сонгох бололцоотойгоор 267 гэмт хэрэгт оногдуулахаар;

- Зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 гэмт хэрэгт бусад ялын төрлөөс сонгож оногдуулахаар;

- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг 68 гэмт хэрэгт хорихоос бусад төрлийн ялаас сонгох бололцоотойгоор оногдуулахаар;

- Эрх хасах ялыг хорих болон бусад төрлийн ялаас сонгох боломжтойгоор 44 гэмт үйлдэлд оногдуулахаар тус тус зохицуулсан байна.

Хүснэгт 1. Шинэчлэн батлагдсан “Эрүүгийн хууль”-д тусгасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь. (Эрүүгийн хууль 2015 он.)



Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг - 240 төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар тогтоосон бөгөөд хөнгөн гэмт хэрэгт - 121, хүнд гэмт хэрэгт - 119 тохиолдолд

тус тус оногдуулахаар тогтоосон байна. Үүнд:

- зорчих эрхийг хязгаарлах ял эсхүл хорих ялын аль нэгийг сонгож оногдуулахаар - 176 гэмт хэрэгт,

- зорчих эрхийг хязгаарлах ялыг торгох ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 153 гэмт хэрэгт;

- зорчих эрхийг хязгаарлах ял, торгох эсхүл нийгэд тустай ажил хийлгэх ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 48 заалтад оногдуулахаар тогтоожээ.

Дээрх судалгаанаас үзэхэд “зорчих эрхийг хязгаарлах” эсхүл “хорих ял”-ын аль нэгийг сонгож хэрэглэхээр ихэвчлэн хүнд гэмт хэрэгт буюу – 119 заалтад, хөнгөн гэмт хэрэгт буюу – 57 заалтад “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, болон “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” “авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-г түлхүү оногдуулахаар хуульчилсан байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялын эерэг үр нөлөө

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын хэрэглээний судалгааг харахад “зорчих эрхийг хязгаарлах” эсхүл “хорих ял”-ын аль нэгийг сонгож оногдуулах зохицуулалт түлхүү байх тул дээрх

хоёр ялын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө /последствия/ талаас судалж үзэх нь зүйтэй юм.

Хорих анги, байгууллагад яд эдэлж буй хоригдогчийн тоо, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардал буурах, улсын төсөвт хэмнэлт хийх хүрээнд:

Хоригдолд ногдох нэг өдрийн дундаж зардал 7231 төгрөг, жилд 2.639.619 төгрөг байна. Шууд зардалд цахилгаан, түлш, халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар, хичээл үйлдвэрлэл, нормын хувцас зөөлөн эдлэл, хоол, эм, эрүүл мэндийн даатгал шууд бус зардалд харуул хамгаалалтын цалин, тээвэр шатахуун, харуул хамгаалалтын багаж, сэлбэг хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг оруулсан⁴⁶.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны нэг өдрийн дундаж зардлыг дараах байдлаар тооцсон. Үүнд: шууд зардалд сим карт, дата/500мв/ эрхийн үйлчилгээг оруулсан. Шууд бус зардалд алба хаагчдын цалин, тээвэр, шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо интернетийн төлбөрийг оруулан тооцон нэг өдрийн дундаж зардлыг эхний жил 3313 төгрөг, жилд 1.209.173 төгрөг гэж тооцоолсон. Хорих ялын зардлаас 3918 төгрөг буюу 54.1 хувиар бага байна⁴⁷.

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс буюу шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж эхэлсэн цаг үеэс “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д аймаг, нийслэл, сум дүүргийн шүүхийн шүүгчийн захирамжаар зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлж -77, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн

⁴⁶ Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилэхэд шаардагдах зардлын тооцоо.

Хууль зүй, дотоод хэргийн яам. УБ.,2020. 17 дахь тал.

⁴⁷ Мөн тэнд. 18 дахь тал.

баталсан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж - 983 ялтан тус тус хяналтад орсон байна.

2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллагад 4070 хоригдол хоригдож байснаас “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, ял дүйцүүлэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн -983 ялтан суллагдаж, цахим хяналтад шилжсэн нь “Цахим хяналт, удирдлагын төв” болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг даруй 80-90 хувь нэмэгдүүлсэн ч нийгэм, эдийн засагт учруулж байсан ачааг

“тодорхой хэмжээгээр хөнгөлж чадсан” гэж судлаачийн хувьд үздэг.

Шинэчлэн батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 169 дүгээр зүйлийн 169.1-т “Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй” гэж заасан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төрийн сангийн дансанд 30 орчим сая төгрөгний цахим бугуйвч, дагалдах хэрэгсэл” ашигласны төлбөр төлөгдсөн байна.

Улсаас хорих анги, байгууллагад ял эдэлж буй хоригдлын нэг өдрийн дундаж зардалд өдөрт 10 орчим мянга, 1 жилд дунджаар орчим 2 сая төгрөгний зардал гаргаж байсан бол зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж,

Нэг ялтанд ногдох дундаж зардал
Эхний жил

	Нийт төсөв	Хүний тоо /58+1080+ 20/	ялтны эзлэх хувь		Нэг өдрийн зардал
1. Шууд зардал					
Дата /500 МВ/	5,400,000.00	1,158.00	0.93	5,036,269.43	12.78
Сим карт	10,800,000.00	1,158.00	0.93	10,072,538.86	25.55
Бусад зардал					3,274.47
Дүн	16,200,000.00				3,312.80
Жилийн зардал					1,209,172.71
2. Шууд бус зардал					
Алба хаагчдын цалин	1,013,026,800.00	1,158.00	0.93	944,791,834.20	2,396.7
Тээвэр шатахуун	146,059,200.00	1,158.00	0.93	136,221,015.54	345.6
Бичиг хэргийн зардал	4,026,000.00	1,158.00	0.93	3,754,818.65	9.5
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	220,910,000.00	1,158.00	0.93	206,030,051.81	522.7
Дүн	1,384,022,000.00				3,274.5
Нэг ялтанд ногдох дундаж зардал 2 дахь жил					
	Нийт төсөв	Хүний тоо /58+1500+ 20/	ялтны эзлэх хувь		Нэг өдрийн зардал
1. Шууд зардал					
Дата /500 МВ/	7,500,000.00	1,578.00	0.95	7,129,277.57	13.02
Сим карт	15,000,000.00	1,578.00	0.95	14,258,555.13	26.04
Бусад зардал					2,402.94
Дүн	22,500,000.00				2,442.01
Жилийн зардал					891,332.07

биелэлтийг хангуулж эхэлснээр улсын төсөвт
орлогоор 8 сарын хугацаанд 30 орчим сая
төгрөг орж ирсэн нь зорчих эрхийг хязгаарлах

улс орны эдийн засагт үзүүлэх “эерэг нөлөө” мэдэгдэхүйц хэмжээгээр харагдаж эхэлсэн гэж үзэж болохоор байна.

Мөн хугацаанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацаандаа хуульд заасан үндэслэл журмын дагуу 27 ялтны зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж ажилласан бөгөөд эдгээрээс “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн -23, Аймаг, нийслэлийн сум дундын шүүхийн захирамжаар зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн – 4 ялтны эдлээгүй үлдсэн ялыг хорих ялаар сольсон байна.

“Зорчих эрхийг хязгаарлах хяналтын систем”-д бүртгэгдсэн нийт зөрчлөөс 70-80 хувь нь “өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтын зүгээс гаргасан зөрчил эзэлж байгаа

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛААР ШИЙТГҮҮЛСЭН НЭГ ЯЛТАНД НОГДОХ ДУНДАЖ ЗАРДАЛ /ТӨГРӨГ/

Техникийн талаас хяналт тавихад тулгарч буй асуудал.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч нь “хориглосон бүсэд нэвтрэх”, “хязгаарласан бүсээс гарах”, “бүсийн хязгаарт ойртсон”, “явах маршрутаас гарсан” зэрэг тохиолдолд цахим бугуйвчид анхааруулах мессеж илгээх болон “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн “хяналтын нэгдсэн систем”-д 24 цагийн турш тасралтгүй “анхааруулга, дохио” дамжуулах горимоор ажилладаг.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг зөвхөн “үүрэн холбоо

болон ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан 28 ялтнаас 27 нь мөн л “өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдан ял дүйцүүлж, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан байгаа нь зорчих эрхийг хязгаарлах ялын нийгэмд үзүүлж буй эерэг үр нөлөө хорих ялаас хавьгүй илүү болохыг илтгэн харуулж байна.

“Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамрагдаж, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн хоногийг хорих ялаар сольсон – 23, Аймаг, нийслэлийн сум дундын шүүхийн захирамжаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн – 4 ялтны эдлээгүй үлдсэн ялыг хорих ялаар сольсон байна.

сүлжээ” орсон газарт хангуулах боломжтой тул Монгол Улсын газар нутгийн “засаг захиргааны нэгжүүд /аймаг, нийслэл, сум, баг, хороо/-д хамгийн түгээмэл тархсан “үүрэн холбооны оператор” болон “2G сүлжээ” дэмждэг цахим бугуйвчийг сонгон ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж байна.

Ялтанд тавих техникийн хяналтыг “үүрэн холбооны сүлжээний /сим карт, 2G data/” буюу түүний мэдээлэл дамжуулагч/GPS/-ийн тусламжтайгаар гэмт этгээдийн “байршил, хөдөлгөөн”-ийг тогтоож, тухайн мэдээллийг цахим хяналтын системд мэдээлэх байдлаар хяналтыг хэрэгжүүлдэг.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй “цахим бугуйвч” нь БНХАУ-д үйлдвэрлэсэн бөгөөд “2G сүлжээ”-ний “data” буюу интернетийн хурдаар мэдээлэл дамжуулан хяналтыг цахимаар тавих боломжтой байдлаар зохицуулагдсан байна.

“2G сүлжээ нь” тархцын хувьд манай орны нутаг дэвсгэрийг өргөн хамрах хэдий ч мэдээлэл, дохио дамжуулах хурд нь “384 kbps” буюу “3G сүлжээ”-нээс даруй 112 дахин бага хурд, хүчин чадалтайгаас гадна үүрэн холбооны ачааллаас шалтгаалан сүлжээ унах, тодорхойгүй хугацаагаар тасрах, мэдээлэл дамжуулагч нь цемент, төмөр, бетон, тоосгоор баригдсан барилга, байгууламж болон байгалийн төрөл бүрийн тогтоц /өндөр уул, даваа, нугачаа/-д ойж, сарнин “алдах, хүлцэх” тохиолдол түгээмэл байдаг.

1. Сүлжээтэй холбоотой тулгарч буй асуудал:

- Үүрэн холбооны тархцын антенаас хамаарсан сүлжээний тасалдал, доголдол болон дата дугаар ашиглахтай холбогдон гарсан зардал түүний тогтмол төлөлтийн асуудал;


- Цахим бугуйвчийн байршил тогтоогч (GPS) огноо орон байр/объект/-аас гарах хөдөлгөөн хийгээгүй үед хиймэл дагуулаас ирсэн мэдээллийн сүүлийн байршилд тухайн цагт гацаж, явсан маршрутыг заадаггүй;

- Улсын хэмжээнд нийт зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны амьдарч буй орчин нөхцөлөөр нь судалж үзэхэд:

- Гэр хороололд болон монгол гэр, хувийн байшинд амьдарч байгаа ялтан нь хиймэл дагуул хөдөлгөөн мэдэрхэд саатах зүйл байхгүй тул *байршил хэвийн заадаг*, Харин ялтан орон сууцанд, объектод орсон үед “хиймэл дагуулаас цахим бугуйвч байршлын мэдээ хүлээн авах боломжгүй болдог тул ойлтын цэгүүд үүссэнээр байршил тогтоогч (GPS)-ийн огноо *тухайн хөдөлгөөн хийсэн сүүлийн цагт заан гацаж, дараагийн цэгийг заахгүй байгаа нь ялтныг цахим хяналтаас алдах, ял завиуулах эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.*

Зураг 1. Үүрэн холбооны технологийн хөгжлийн зураг.

Үүрэн холбооны технологийн хөгжил



2. Цахим бугуйвчтай холбоотой асуудал:

Цахим хяналт, удирдлагын төвд нийт – 1080-2100 ширхэг цахим бугуйвч зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд бүртгэлтэй байгаагаас гарт зүүх – 980- ширхэг, хөлөнд зүүх – 100 ширхэг байгаа бөгөөд үүнээс – 20 ширхэг гарт зүүх цахим бугуйвчийг ашиглаж байна.


Цахим бугуйвч нь “хүний биед харшил өгөхгүй, хүний гар болон хөлд зүүхээр тохируулсан, хөнгөн жинтэй, ус, доргио, шорооны хамгаалалттай, халуун хүйтэнд тэсвэрлэх” боломжтой бөгөөд “таслах, тайлах, оролдох” үед хяналтын нэгдсэн системд анхааруулга өгөх горимоор ажилладаг бөгөөд “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д нийт 9-10 төрлийн анхааруулга дохио ирдэг. Үүнд:

- Цэнэг дуусаж байна 30%.

- Цэнэг дуусаж байна 5%, Яаралтай цэнэглэнэ үү.

- Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан.
- Яаралтай үеийн дуудлага. (SOS)
- Маршрутаас гарсан.
- Хориглосон бүсэд 200 метр ойртсон.
- Хориглосон бүсэд нэвтэрсэн
- Бугуйвч оосор тайлагдсан.
- Бүсийн хязгаарт 200 метр ойртсон.

Зураг 2. Цахим хяналтын системд ирсэн анхааруулгын судалгаа



2023 он “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д цахим хяналт ажиллахад нийт 1643 “анхааруулга, дохио” ирсэн бөгөөд “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн алба хаагчид хариуцсан шийдвэр гүйцэтгэгч тухай бүр мэдэгдэж, илэрсэн “зөрчил, дутагдал”-ыг тухай бүр арилгаж, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажилласан байна.

“Зорчих эрхийг хязгаарлах хяналтын систем”-д ялтан бүртгэж, хяналтад авсан цаг үеэс хойш хяналтын системд ирсэн нийт анхааруулга дохионоос 87% хувийг “Цэнэг дуусаж байна 30%” гэсэн “анхааруулга, дохио” эзэлж байгаа нь ялтанд зүүлгэсэн “цахим бугуйвч”-ийн батарей цэнэгээ хангалтгүй барьж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвчаар хяналт тавихад дараах хүндрэлтэй асуудлууд байна. Үүнд:

- Цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй бөгөөд суурин цахилгааны эх үүсвэрээр зориулалтын цэнэглэлэгч/толин/-ээр бүрэн цэнэглэсэн үедээ *цэнэгээ барих хугацаа нь хагас өдөр буюу 10-12 цагаас хэтрэхгүй;*

- Зориулалт/толин/ цэнэглэгчээр суурин цахилгаан эх үүсвэрт холбож бүрэн цэнэглэхэд дунджаар 1 цаг 30 минутын хугацаа зарцуулдаг бөгөөд цэнэглэх хугацаанд ялтан нь нэг цэгт хөдөлгөөнгүй удаан байрлах шаардлагатай, цахим бугуйвчийн зориулалт/толин/ цэнэглэгч нь хэтэрхий богинохон тул цэнэглэхэд

хүндрэлтэй/ толин цэнэглэгч нь 40 см урттай/

- Зөөврийн цэнэглэгчээр “цахим бугуйвч”-ийг зөвхөн 1 удаа бүрэн цэнэглэх боломжтой, зөөврийн цэнэглэгчээр цахим бугуйвчийг бүрэн цэнэглэхэд ойролцоогоор 30-40 минут зарцуулах бөгөөд цэнэг барих хугацаа харьцангуй богино буюу 4-5 цаг.

- Түүнчлэн ял эдэлж буй 20 ялтнаас хүндрэлтэй асуудлын талаар судалгаа авахад 16 ялтан “Цахим бугуйвчийг цэнэглэхэд хүндрэлтэй, цэнэг нь хурдан дуусдаг” гэсэн яриа өгүүлэлтэй байна.

Зураг 3. Гарын цахим бугуйвчийн иж бүрдэл.



“Бүсийн хязгаарт 200 метр ойртсон” анхааруулга 8% хувийг эзэлж байгаа нь шүүхийн шийтгэх тогтоолын дагуу тухайн бүсийг зурж системд оруулахад хяналтад орж буй ялтан өөрийн зорчих бүсийн хязгаарыг мэдээгүй байдлаас үүдэлтэй.


“Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан” анхааруулга 5% хувийг эзэлж байгаа нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан бүсийн хязгаарыг мэдэхгүй гарах, мөн зарим тохиолдолд цахим бугуйвчаас шалтгаалсан

маршрут хэвийн зааж байхад 5-10 секундын хугацаанд байрлал тогтоогч нь үсэрч байрлалыг буруу зааж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Цахим бугуйвч нь “Дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, багасгахад тустай”.

Зураг 4. Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд ирсэн анхааруулга, болон зөрчил

Анхааруулга, зөрчил



Техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудал.

Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” болон “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”, “Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам”, “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд нэвтрэх ашиглах журам”-ыг тус тус үйл мөрдлөг болгон ажиллаж байгаа ч дараах хүндрэлтэй асуудлууд байна. Үүнд:

1. “Шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 171 дүгээр зүйлийн “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг сонгох хэсэг”-м “Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр

гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно” гэж заасан бөгөөд одоогийн байдлаар хяналтын тоног төхөөрөмжүүдийг “Цахим хяналт, удирдлагын төв” бүрэн хариуцаж байгаа бөгөөд тус хяналтын “тоног төхөөрөмжийг сонгох, ял эдлүүлэх ажиллагаанд ашиглуулах” талаар огт зохицуулаагүй;

2. Мөн хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т “Шийдвэр гүйцэтгэгч ялтанд биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болно” гэсэн бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн тасралтгүй хяналтын хэрхэн тавих талаар хуулийн зохицуулалт огт байхгүй;

3. 172 дугаар зүйлд “Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирүүлсэн зөрчлийн дохиог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаархи мэдээллийг

хүргүүлнэ” гэж заасан нь нэр томъёоны хувьд зөвхөн “Цахим хяналт, удирдлагын төвийн техник хяналтын ажилтаны чиг үүрэгт хамаарах бөгөөд тус төвийн ерөнхий зохицуулагч болон хяналтын операторын чиг үүрэгт хамаарахгүй байдлаар зохицуулсан байгаа нь тус ялын биелэлтийн нэг мөр хангахад харьяа салбар, нэгжийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нартай харилцан уялдаатай ажиллахад хүндрэл үүсгэхээс гадна цахим, хяналт удирдлагын төвөөс мэргэжлийн удирдлагын удирдлагаар хангах эрх зүйн зохицуулалт огт тусаагүй байна.

4. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ын 3.2-т “Зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна” гэж зохицуулсан ч практикт үүрэн холбооны операторын төлбөрийг сар тутам тухай шаардлагаас үүдэн дээрх зохицуулалт мөрдөгдөхгүй байна./Үүрэн холбооны операторын төлбөрийг сард нь багтаан төлөөгүйн ялмаас 12 ялтны дата дугаар хаагдаж, хяналтаас 2-3 хугацаанд алсдсан тохиолдол гарч байсан/

Дүгнэлт, санал

Дээрхээс дүгнэхэд Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй хяналтын тоног

төхөөрөмжүүд шаардлага хангахгүй байна. Үүрэн холбооны /2 G сүлжээ/-ний /GPS/ нь байршлаа буруу заадаг, “алдах, хүлцэх” зай ихтэй, ялтанд зүүлгэсэн цахим бугуйвч нь цэнэглэхэд хүдрэлтэй, цэнэгээ хангалтгүй барьдаг зэрэг нь ялтныг техникийн тасралтгүй хяналтаас алдах эрсдэлийг үүсгэхээр байна.

Түүнчлэн цахим бугуйвч нь “2G сүлжээ”-г ашиглан байршлаа тодорхойлон мэдээлэл солилцож, дамжуулдаг бөгөөд “сүлжээний доголдол, мэдээлэл дамжуулах хурд”-аас шалтгаалан ялтны байршлыг буруу мэдээлэлж, байршил тогтоогч нь ялтан “нэг байрлалдаа удаан байсан хамгийн сүүлчийн цэг /хаяг/-т зааж, гацдаг” гэж дүгнэж болохоор байна

Цахим хяналтаар илэрсэн алдаа, дутагдлаас харахад төв суурин газар, тэр дундаа “барилга, орон сууц”-д байгаа ялтны байршлыг тогтооход байршил тогтоогч тухайн цэгтээ гацах, дараагийн байршлыг заахгүй байх, огт ажиллагаагүй болох эрсдэлтэйгээс гадна нэгдсэн системд хянагдах ялтны тоо нэмэгдсэн тохиолдолд ялтан тус бүрийн цахим бугуйвчийн “GPS огноо”-г нэг бүрчилэн хянаж, байршлаа зөв зааж байгаа эсэхийг тогтооход хүндрэлтэй байна.

Аливаа шинэ ажлыг хэрэгжүүлэхэд алдаа оноо гарах, сурч дадлагажих асуудал түгээмэл байдаг хэдий ч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны бодит нөхцөл байдалд “дүн шинжилгээ, судалгаа хийхгүй орхих”, “техникийн боломжид баригдаж “эрүүгийн хариуцлага, ялын зорилго, үр нөлөөг бууруулах” ялтанд

завшуулах, ял гарцаагүй байх зарчим алдагдах нөхцөл байдлыг үүсгэхээр байна.

Шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй “хүндрэл, бэрхшээл”-ийг шийдвэрлэхэд гадаадын улс орнуудын тусламж дэмжлэг авах, төсөл хөтөлбөрт хамтарч ажиллах нь одоогийн нөхцөлд оновчтой шийдвэр боловч цаашид өөрийн орны эрдэмтэн судлаач, зохион бүтээгчдийн “инновац”-ийн бүтээлийг ашиглаж ялын хэрэгжилтийг хангахад ашиглаж буй “тоног төхөөрөмж, техник хэрэгсэл”-ийг Монгол улс өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан дотооддоо үйлдвэрлэж, эдийн засгийн бодит хэмнэлт гаргах боломжтой гэж дүгнэж байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 172 дугаар зүйлд “Цахим хяналт, удирдлагын төв нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд тасралтгүй хяналт тавьж, ял эдлүүлэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангана” гэсэн заалт нэмэх;

2. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 172 дугаар зүйлийн 172.1-д заасан “Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирүүлсэн зөрчлийн дохиог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаархи мэдээллийг хүргүүлнэ” гэснийг;

-Цахим хяналт, удирдлагын төвийн ерөнхий зохицуулагч, техник хяналтын ажилтан, хяналтын оператор

нь мэдээллийн санд ирсэн “анхааруулга дохио”-г хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтанд нэн даруй мэдэгдэж, зөрчлийг арилгуулах, биечлэн хяналт тавих үүрэг, чиглэлийг өгч ажиллана” гэж өөрчлөх;

3. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ын 3.2-т “Зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн ялтан зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна” гэсэн хэсэгт;

-“Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан үүрэн холбооны операторын төлбөрийг хяналтын тоног төхөөрөмж зүүхээс өмнө нийт ял эдлэх хугацаагаар тооцоолж төлнө” гэсэн заалт шинээр нэмэх;

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд тавих техникийн хяналтыг сайжруулах үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дотооддоо зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглаж буй “цахим бугуйвч, хяналтын төхөөрөмж”-ийг үйлдвэрлэх нөөц бололцоог судлах, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах.

2. Цахим хяналт, удирдлагын төвд ашиглагдаж байгаа “2

Г сүлжээ”-г дэмжигч 1080 ширхэг цахим бугуйвчийг 3 Г сүлжээнд нэвтрүүлэх боломжийг судлах,

3. Шинээр цахим бугуйвчийн хангалт хийх тохиолдолд “3G сүлжээ”-г дэмждэг цахим бугуйвчийн хангалт хийх;

4. “3 Г сүлжээ”-г нэвтрүүлэх боломжгүй тохиолдолд “2 Г сүлжээ”-ний хүчин чадлыг сайжруулах тоног төхөөрөмжийг талаар судалгааг хийж, ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэх

Ашигласан эх сурвалжийн

жагсаалт:

1. Доктор(Phd) Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2017. 411 дэх тал.

2. Доктор(Phd) Д.Дамдинцэрэн. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах эмхтгэл”.УБ., 2021.11 дэх тал.

3. Э.Жамбалрагчаа, Э.Урангоо, Б.Дэнсмаа. “Монгол Улсын Эрүүгийн хуулин дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ерөнхий газрын “Сүлд-Инфо сэтгүүл” УБ., 2021.60 дахь тал

4. Ч.Болд, Э. Жамбалрагчаа. “Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд: Гадаад орны туршлага”. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ.,2018. 159 дахь тал.

5. Ходжалиев. С.А. Теория и практика ограничения свободы как вида наказания. Грозный.,2019. С.75. РФ. /Ходжалиев. С.А. Зорчих эрхийг хязгаарлах ялын онол, практикийн асуудал. Грозный., 2019. 75 дахь тал. Оросын Холбооны Улс.

6. ОХУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл 2010. № 14. [http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_99050/\(хандалт-10.01.2018 он\)](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_99050/(хандалт-10.01.2018 он))

7. Федеральное государственное унитарное предприятие "Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний <http://www.citosfsin.ru/company/index.php> (хандалт-10.01.2018 он)

8. Kathy Padgett, William Bales and Thomas Blomberg (2006) "Under Surveillance: An Empirical Test of the Effectiveness and Consequences of Electronic Monitoring" Criminology and Public Policy, pages 61 - 91